



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2026/191/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх

Утас: 70363040

Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор:

Ц.Отгонбаяр

Утас: 70363036

Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Аудитын гүйцэтгэсэн: Бэйкер Тилли Далайван аудит ХХК-н
Дархан салбар

Утас: 99396969 Цахим хаяг: urtaa6969@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХҮДЭР СУМЫН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ В.ЦЭРЭНСҮРЭН ТАНАА

2026.02.25 № СМА-2026/191/НА-СМА-ТЧЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хүдэр сумын нэгдүгээр цэцэрлэг нь Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 13,693.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2025 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 88.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас, үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	170,602,472.90	52,199,088.33
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	170,602,472.90	52,199,088.33
3121	Төгрөг	170,602,472.90	52,199,088.33
31211	Төрийн сангийн харилцах	170,602,472.90	52,199,088.33
33	АВЛАГА		
35	БАРАА МАТЕРИАЛ	85,653,472.80	94,379,944.80
354	Хангамжийн материал	85,653,472.80	94,379,944.80
3541	Бичиг хэргийн материал	533,600.00	541,600.00
3542	Аж ахуйн материал	53,542,586.80	53,502,486.80
3546	Хүнсний материал	2,885,536.00	7,082,258.00
3547	Бусад хангамжийн материал	28,691,750.00	33,253,600.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	256,255,945.70	146,579,033.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,143,985,183.68	1,140,300,587.74
392	Биет хөрөнгө	1,133,911,183.68	1,129,776,587.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,300,331,468.19	1,300,331,468.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(215,731,021.65)	(254,102,750.85)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,012,580.00	55,388,980.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,062,181.62)	(12,206,646.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,462,289.50	61,482,316.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44,874,786.32)	(24,093,833.55)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,957,813.50	7,957,813.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,774,687.92)	(5,570,469.24)
39217	Ном	589,710.00	589,710.00
393	Биет бус хөрөнгө	10,074,000.00	10,524,000.00
39301	Програм хангамж		450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,074,000.00	10,074,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,143,985,183.68	1,140,300,587.74
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,400,241,129.38	1,286,879,620.87
51	Засгийн газрын хувь оролцоо	1,400,241,129.38	1,286,879,620.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	85,202,272.00	85,202,272.00
51101	Өмч: - төрийн	85,202,272.00	85,202,272.00
512	Хуримтлагдсан үр дүн	521,392,832.50	373,575,863.99
5121	Өмнөх үеийн үр дүн	521,392,832.50	521,392,832.50
5122	Тайлант үеийн үр дүн		(147,816,968.51)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	793,646,024.88	828,101,484.88
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,400,241,129.38	1,286,879,620.87
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,400,241,129.38	1,286,879,620.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	965,680,164.27	1,084,900,008.65
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	907,618,000.00	1,019,829,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	907,618,000.00	1,019,829,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	58,062,164.27	65,071,008.65
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,062,164.27	65,071,008.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,013,030.00	24,051,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,013,030.00	24,051,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	12,623,030.00	8,981,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,390,000.00	15,070,700.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	982,693,194.27	1,108,951,708.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	973,715,997.74	1,256,768,677.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	973,715,997.74	1,243,075,597.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	676,012,970.08	900,224,478.93
210101	Үндсэн цалин	438,428,328.54	542,672,381.40
210102	Нэмэгдэл	219,590,684.86	311,854,472.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт		14,731,021.00
210104	Урамшуулал	17,993,956.68	30,966,604.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,841,799.48	104,413,980.14
210201	Тэтгэврийн даатгал	59,280,354.17	70,998,590.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,056,482.21	8,362,594.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,416,140.97	4,182,847.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,217,823.24	4,178,170.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,870,998.89	16,691,779.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,592,164.27	57,384,612.65
210301	Гэрэл, цахилгаан	7,331,124.27	10,123,572.65
210302	Түлш, халаалт	41,081,040.00	41,081,040.00
210303	Цэвэр, бохир ус	6,180,000.00	6,180,000.00
2105	Нормативт зардал	78,316,739.00	79,773,423.50
210502	Хоол, хүнс	78,316,739.00	79,773,423.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	7,686,396.00
210604	Урсгал засвар	3,470,000.00	7,686,396.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,359,402.00	2,455,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,359,402.00	2,455,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,122,922.91	91,137,705.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,242,962.20	31,944,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,953,207.00	7,508,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	53,926,753.71	51,684,355.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		13,693,080.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		13,693,080.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		13,693,080.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	973,715,997.74	1,256,768,677.16
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,977,196.53	(147,816,968.51)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,977,196.53	(147,816,968.51)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	965,680,164.27	1,084,900,008.65
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	965,680,164.27	1,084,900,008.65
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	907,618,000.00	1,019,829,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	907,618,000.00	1,019,829,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	58,062,164.27	65,071,008.65
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,062,164.27	65,071,008.65
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	935,525,380.83	1,198,740,093.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	935,525,380.83	1,198,740,093.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	935,525,380.83	1,185,047,013.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	676,012,970.08	900,224,478.93
210101	Үндсэн цалин	438,428,328.54	542,672,381.40
210102	Нэмэгдэл	219,590,684.86	311,854,472.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт		14,731,021.00
210104	Урамшуулал	17,993,956.68	30,966,604.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,910,549.48	104,413,980.14
210201	Тэтгэврийн даатгал	59,327,104.17	70,998,590.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,061,982.21	8,362,594.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,427,140.97	4,182,847.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,218,923.24	4,178,170.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,875,398.89	16,691,779.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,592,164.27	57,384,612.65
210301	Гэрэл, цахилгаан	7,331,124.27	10,123,572.65
210302	Түлш, халаалт	41,081,040.00	41,081,040.00
210303	Цэвэр, бохир ус	6,180,000.00	6,180,000.00
2105	Нормативт зардал	75,568,595.00	83,970,145.50
210502	Хоол, хүнс	75,568,595.00	83,970,145.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	7,686,396.00
210604	Урсгал засвар	3,470,000.00	7,686,396.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,359,402.00	2,455,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,359,402.00	2,455,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,611,700.00	28,912,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,566,000.00	19,691,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,045,700.00	9,220,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		13,693,080.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		13,693,080.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		13,693,080.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30,154,783.44	(113,840,084.57)

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	960,000.00	4,563,300.00
	Дотоод эх үүсвэрээр	960,000.00	4,563,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	960,000.00	4,563,300.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-960,000.00	(4,563,300.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	29,194,783.44	(118,403,384.57)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		170,602,472.90
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		52,199,088.33

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	85,202,272.00	793,646,024.88	521,392,832.50	1,400,241,129.38
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		34,455,460.00		34,455,460.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
8	Тайлант үеийн үр дүн			(147,816,968.51)	(147,816,968.51)
9	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	85,202,272.00	828,101,484.88	373,575,863.99	1,286,879,620.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,245,190,708.65	1,084,900,008.65	160,290,700.00	87.1
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,180,119,700.00	1,019,829,000.00	160,290,700.00	86.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,180,119,700.00	1,019,829,000.00	160,290,700.00	86.4
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	65,071,008.65	65,071,008.65		100.0
132001	Орон нутгийн төсвөөс	65,071,008.65	65,071,008.65		100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	170,602,472.90		170,602,472.90	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,415,793,181.55	1,084,900,008.65	330,893,172.90	76.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,245,190,708.65	1,198,740,093.22	46,450,615.43	96.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,231,497,508.65	1,185,047,013.22	46,450,495.43	96.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	917,557,900.00	900,224,478.93	17,333,421.07	98.1
210101	Үндсэн цалин	569,432,400.00	542,672,381.40	26,760,018.60	95.3
210102	Нэмэгдэл	312,251,000.00	311,854,472.04	396,527.96	99.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт		14,731,021.00	-14,731,021.00	
210104	Урамшуулал	35,874,500.00	30,966,604.49	4,907,895.51	86.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,291,600.00	104,413,980.14	8,877,619.86	92.2
210201	Тэтгэврийн даатгал	76,828,400.00	70,998,590.00	5,829,810.00	92.4
210202	Тэтгэмжийн даатгал	9,115,800.00	8,362,594.00	753,206.00	91.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,557,900.00	4,182,847.00	375,053.00	91.8
210204	Ажилгүйдлийн даатгал	4,557,900.00	4,178,170.00	379,730.00	91.7
210205	Эрүүл мэндийн даатгал	18,231,600.00	16,691,779.14	1,539,820.86	91.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,384,612.65	57,384,612.65		100.0
210301	Гэрэл, цахилгаан	10,123,572.65	10,123,572.65		100.0
210302	Түлш, халаалт	41,081,040.00	41,081,040.00		100.0
210303	Цэвэр, бохир ус	6,180,000.00	6,180,000.00		100.0
2105	Нормативт зардал	96,370,500.00	83,970,145.50	12,400,354.50	87.1
210502	Хоол, хүнс	96,370,500.00	83,970,145.50	12,400,354.50	87.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,686,396.00	7,686,396.00		100.0
210604	Урсгал засвар	7,686,396.00	7,686,396.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,954,500.00	2,455,000.00	499,500.00	83.1

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,954,500.00	2,455,000.00	499,500.00	83.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,252,000.00	28,912,400.00	7,339,600.00	79.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,031,100.00	19,691,600.00	7,339,500.00	72.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,220,900.00	9,220,800.00	100.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,693,200.00	13,693,080.00	120.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,693,200.00	13,693,080.00	120.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,693,200.00	13,693,080.00	120.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		4,563,300.00	(4,563,300.00)	
	Дотоод эх үүсвэрээр		4,563,300.00	(4,563,300.00)	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		4,563,300.00	(4,563,300.00)	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,245,190,708.65	1,203,303,393.22	41,887,315.43	96.6
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		170,602,472.90	(170,602,472.90)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		52,199,088.33	(52,199,088.33)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 6,144.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1,495.7 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 4,648.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **6,144.1** мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон **9,737.1** мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Тооцооллын алдаанаас шалтгаалж 2 ажилтанд ажилласан хоногийг зөрүүтэй тооцож 1,023.3 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

2. Чөлөөний хуудсаар чөлөөтэй байсан үед багш нарт 472.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар зүйлийн 3.1 дэх “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу “илүү цагаар... ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ”, 3.2 “Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн илүү цагаар ажилласны дараа сарын цалин хөлстэй хамт тооцож олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

3.2 Албан шаардлага

1. Цалингийн зардлын батлагдсан төсвөөс ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд **4,648.5** мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажилласан хоногийг зөрүүтэй тооцож цалин илүү олгосон	1	1,023.3	1	1,023.3								
Илүү цагийн хөлс илүү олгосон	1	472.4	1	472.4								
Зардал хооронд гүйлгэн зарцуулж гүйцэтгэлийн бодитоор тайлагнаагүй	1	4,648.4			1	4,648.4						
Дүн	3	6,144.1	2	1,495.7	1	4,648.4						-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

